

ХААН СОЁМБО АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Тариалан НАҮТ” ХХК -ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/04/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2023 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Гүйцэтгэсэн чанарын хяналт, ахлах аудитор: Н.Бадамханд
Утас: 99042699 Цахим хаяг: khaan.soyombo.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.1 “Тариалан Нийтийн ахуйн үйлчилгээний төв” ХХК ба түүний үйл ажиллагаа	8
3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	10
4. Аудитын тайлан	11
4.1 Ерөнхий зүйл	11
4.2 Материаллаг байдал.....	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
4.4.1 Шилэн дансны мэдээлэл.....	11
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
4.5.1 Завсрын аудитын талаар.....	12
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
5. Аудитын илрүүлэлт	12
5.1 Төлбөрийн акт.....	12
5.2 Албан шаардлага	12
5.3 Зөвлөмж.....	13
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн Хурал
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
НАҮТ	Нийтийн ахуйн үйлчилгээний төв
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлчилгээний газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

2022.03.06 № 01/210
танай _____ -ны № _____ -т

“ТАРИАЛАН НИЙТИЙН АХУЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ” ХХК -ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ч.БАТБОЛД
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Тариалан нийтийн ахуйн үйлчилгээний төв” ХХК -ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Тариалан нийтийн ахуйн үйлчилгээний төв” ХХК-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор компанийн дүрмийг шинэчлэн баталжээ. Уг дүрмийн өөрчлөлтөөр компанийн өмчлөгч нь Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болсон байна.

Аудитын гол асуудал

Тариалан сумын Нийтийн аж ахуйн үйлчилгээний газар ХХК-ын ТУЗ нь 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 4 тоот тогтоолоор Хөвсгөл аймгийн ИТХ-аас баталсан зорилтот түвшинд заасан зардлын дүнг 73.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Цаашид зорилтот түвшний зардлын хязгаарыг нэмэгдүүлэхдээ хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

“Тариалан нийтийн ахуйн үйлчилгээний төв” ХХК нь 2022 оны зорилтот түвшний биелэлт 108.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн

тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Д/Д	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2022 оны 01-р сарын 01	2022 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	0.00	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	-
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5,187,200.28	1,557,244.15
1.1.2	Дансны авлага	114,650,870.90	88,572,519.22
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	(0.00)	(0.00)
1.1.4	Бусад авлага	0.00	-
1.1.6	Бараа материал	61,784,003.22	86,261,541.44
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	0.00	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	181,622,074.40	176,391,304.81
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.00	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	988,904,214.74	1,145,922,855.58
1.2.2	Биет бус хөрөнгө	22,171,720.00	22,171,720.00
1.2.3	Биологийн хөрөнгө	0.00	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,011,075,934.74	1,168,094,575.58
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,192,698,009.14	1,344,485,880.39
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	0.00	-
2.1	ӨР ТӨЛБӨР	0.00	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	0.00	-
2.1.1.1	Дансны өглөг	15,827,849.81	35,381,913.64
2.1.1.3	Татварын өр	8,540,250.50	14,320,426.89
2.1.1.4	НДШ - ийн өглөг	(0.00)	(0.00)
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0.00	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	24,368,100.31	49,702,340.53
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	0.00	-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0.00	51,839,045.84
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	51,839,045.84
2.2	Өр төлбөрийн нийт дүн	24,368,100.31	101,541,386.37
2.3	Эзэмшигчдийн өмч	0.00	-
2.3.1	Өмч: - төрийн	186,039,400.00	367,132,300.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	668,998,445.94	668,998,445.94
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	334,530,399.00	334,530,399.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(21,238,336.11)	(127,716,650.92)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	1,168,329,908.83	1,242,944,494.02
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	1,192,698,009.14	1,344,485,880.39

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	739,188,401.58	819,594,880.71
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	673,850,392.50	819,220,106.68
3	Нийт ашиг (алдагдал)	65,338,009.08	374,774.03
4	Түрээсийн орлого	0.00	6,840,000.00
5	Ерөнхий ба удирдлагын зардал	36,982,436.26	56,170,043.00
6	Санхүүгийн зардал	0.00	0.00
7	Бусад зардал	0.00	0.00
8	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	62,377,840.76	(48,955,268.97)

9	Орлогын татварын зардал	2,835,557.28	52,523,045.84
10	Татварын дараах ашиг (алдагдал)	56,140,056.74	(101,478,314.81)
11	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	0.00	0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	56,140,056.74	(101,478,314.81)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
14	Орлогын нийт дүн	56,140,056.74	(101,478,314.81)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2021 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	186,039,400.00	668,998,445.94	167,882,520.00	(31,758,351.66)	991,162,014.28
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	186,039,400.00	668,998,445.94	167,882,520.00	(31,758,351.66)	991,162,014.28
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	25,520,015.54	25,520,015.54
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	166,647,879.00	0.00	166,647,879.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	(15,000,000.00)	(15,000,000.00)
2022 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	186,039,400.00	668,998,445.94	334,530,399.00	(21,238,336.12)	1,168,329,908.82
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(101,478,314.81)	(101,478,314.81)
Өмчид гарсан өөрчлөлт	181,092,900.00	0.00	0.00	0.00	181,092,900.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	(5,000,000.00)	(5,000,000.00)
2022 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	367,132,300.00	668,998,445.94	334,530,399.00	(127,716,650.93)	1,242,944,494.01

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	794,549,494.52	924,044,847.22
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	792,442,165.52	912,003,415.40
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
	Бусад мөнгөн орлого	2,107,329.00	12,041,431.82
1.2	Мөнгөн зарлага (-)	805,836,744.71	850,974,803.35
	Ажиллагчдад төлсөн	189,586,198.00	220,536,286.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	57,936,781.00	66,313,577.15

	Бараа материал худалдан авахад төлсөн	235,965,944.00	193,616,313.13
	Ашиглалтын зардалд төлсөн	47,980,272.00	59,086,949.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	121,786,943.00	210,400,228.05
	Татварын байгууллагад төлсөн	71,831,037.71	55,446,236.95
	Даатгалын төлбөрт төлсөн	1,007,874.00	0.00
	Бусад мөнгөн зарлага	79,741,695.00	45,575,213.07
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(11,287,250.19)	73,070,043.87
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	71,700,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		71,700,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	(71,700,000.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(15,000,000.00)	(5,000,000.00)
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(26,287,250.19)	(3,629,956.13)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	31,474,450.47	5,187,200.28
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,187,200.28	1,557,224.15

2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

№	Орлогын ангилал	2022 оны төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт	Хувь
1	Халаалтын орлого	727,820,652	755,513,181	(27,692,529)	103.8
2	Халуун усны орлого	6,050,000	8,947,000	(2,897,000)	147.8
3	Бохир ус соруулсны орлого	9,440,000	12,056,818	(2,616,818)	127.7
4	Цэвэр усны орлого	18,478,284	21,911,202	(3,432,918)	118.5
5	Бусад орлого		18,352,734	(18,352,734)	
6	Түрээсийн орлого	1,440,000	1,710,000	(270,000)	118.7
	Нийт орлогын дүн	763,228,936	818,490,935	(55,261,999)	107.2
НИЙТ ЗАРДАЛ					
1	Цалин	246,641,505	257,552,171	(10,910,666)	104.4
2	НДШ	30,830,188	32,571,122	(1,740,934)	105.6
3	ХХОАТ				
4	НӨАТ				
5	Нүүрс	101,453,000	120,752,032	(19,299,032)	119.0
6	Гэрэл цахилгаан зардал	62,021,626	63,700,000	(1,678,374)	102.7
7	Шатахууны зардал	27,260,000	27,260,000	(1,240,450)	100.0
8	Бичиг хэрэг	869,500	869,500		100.0
9	ТУЗ	7,883,400	4,455,000	3,428,400	56.5
10	Хөдөлмөр хамгаалал	11,083,200	5,951,910	5,131,290	53.7
11	Томиллолт	420,000	690,000	(270,000)	164.2
12	Холбооны зардал	744,000	491,500	252,500	66.0
13	Элэгдлийн зардал	67,186,500	67,186,500		100.0
14	Контор хангамж				
15	Засвар үйлчилгээний зардал	7,631,500	7,743,000	(111,500)	101.4
16	Гамшгийн зардал	5,000,000	7,882,950	(2,882,950)	157.6
17	Цахилгаан генератор 100квт	15,000,000	15,000,000		100.0

18	Тэтгэмж урамшуулал	4,500,000	10,052,000	(5,552,000)	233.3
19	Төлбөр хураамж	6,244,000	5,525,167	718,833	88.4
20	Тээврийн хөлс	109,835,000	149,632,900	(39,797,900)	136.2
21	Ногдол ашиг	5,000,000	5,000,000		100.0
22	Тоног төхөөрөмж шинэчлэх	3,000,000	3,000,000		100.0
	Нохой устгал	3,500,000	3,500,000		100.0
	Тэтгэврийн зардал	16,237,374	16,386,460	(149,086)	100.9
23	ҮХөрөнгө данснаас хассан гарз				
24	Нийт зардлын дүн	754,863,908	818,490,935	(63,627,027)	108.4

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 “Тариалан Нийтийн ахуйн үйлчилгээний төв” ХХК ба түүний үйл ажиллагаа

Тус компани нь 100 хувь орон нутгийн өмчит компани бөгөөд хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг Хөвсгөл аймаг, Тариалан сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал хэрэгжүүлнэ.

Компани нь нийт 32 ажилтантай ба Төлөөлөн удирдах зөвлөлийн 5 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Компанийн үндсэн зорилго нь дулаан үйлдвэрлэх, түгээх, хангах, байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн хооронд байгуулсан гэрээний дагуу ая тухтай ажиллах, сурч боловсрох, амьдрах боломжоор хангахад оршино. Энэ зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг эрхэлдэг.

- Дулаан үйлдвэрлэх, түгээх, борлуулах
- Ус хуримтлуулан ариутгаж түгээх үйл ажиллагаа

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Компани нь 2007 оноос ОНӨААТҮГ хэлбэртэйгээр үйл ажиллагаа явуулж байгаад Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн тогтоолоор “Тариалан Нийтийн ахуйн үйлчилгээний төв” ХХК болон өөрчлөгдсөн байна.

Компани нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, бусад холбогдох хууль, тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж байна. Тайлант хугацаанд дээрх хуулиудад материаллаг хэмжээний өөрчлөлт гараагүй болно.

Компанийн гүйцэтгэх захирлыг Хөвсгөл аймгийн Тариалан сумын “Тариалан Нийтийн ахуйн үйлчилгээний төв” ХХК -ийн ТУЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 28-ны тогтоолоор томилсон байна.

Байгууллагын дотоод хяналт, шалгалтын нэгжийг 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дугаар захирлын тушаалаар томилсон байна.

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 4 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар компанийн дүрмийг шинэчлэн баталжээ. Уг дүрмийн өөрчлөлтөөр компанийн өмчлөгч нь Хөвсгөл аймгийн ИТХ болсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Тариалан Нийтийн ахуйн үйлчилгээний төв” ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу иж бүрэн бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Тариалан Нийтийн ахуйн үйлчилгээний төв” ХХК нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2018 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр захирлын тушаалаар баталсан бөгөөд 2023 оны 09 дүгээр сарын 1-ний дотор шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

Компани нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэдэг ба бараа материалыг эхэлж зарлагдах аргаар бүртгэж тайлагнадаг.

Санхүүгийн бүртгэлийн программаар Leader программыг ашигладаг ба үйл ажиллагааны онцлогт нь бүрэн тохироогүй эдийн засгийн орчинд ашиглагдаж байгаа бусад системтэй уялдаагүй мэдээлэл солилцоход хүндрэлтэй, систем дотроо цалин хөлс, урьд оны үлдэгдэл зэрэг мэдээллийг дутуу татаж санхүүгийн тайланг алдаатай илэрхийлж, дахин дахин тооцоолохтой холбогдож нягтлан бодогчид болон бидний ажилд хүндрэл учруулж байна.

Тухайлбал: Өртөг, зардлын хуваарилалтыг бүрэн хийх боломжгүй, гар ажиллагаа ихтэй байна.

“Тариалан Нийтийн ахуйн үйлчилгээний төв” ХХК-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 151.8 сая төгрөгөөр буюу 12.7 хувиар өсөж 1,344.5 сая төгрөг болсон байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5.2	1.5	(3.7)
Авлага	114.6	88.6	(26.0)
Бараа материал	61.8	86.3	24.5
Үндсэн хөрөнгө	988.9	1,145.9	157.0
Биет бус хөрөнгө	22.2	22.2	-
Нийт хөрөнгө	1,192.7	1,344.5	151.8
Өр төлбөр	24.4	49.7	25.3
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,168.3	1,242.9	74.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,192.7	1,344.5	151.8

Дансны авлагын үлдэгдэл 26.0 сая төгрөгөөр буурч 88.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 86.3 сая төгрөг болж өмнөх оноос 24.5 сая төгрөгөөр өссөн нь нүүрсний үнэ ханш нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны хөдөлгөөн дараах шалтгаанаар өөрчлөгдсөн байна. Үүнд:

- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Ковш-30 машин 63.4 сая төгрөгөөр авсан
- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 78.2 сая төгрөгийн гудамжны гэрэлтүүлэг авсан байна.

3.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Компанийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 119 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралаар “Тариалан Нийтийн ахуйн үйлчилгээний төв” ХХК -ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг баталсан байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 22-ний өдрийн 07 дугаар тогтоолоор бизнес төлөвлөгөөг нийт орлогыг 763.2 сая төгрөгөөр, нийт зардлыг 754.9 сая төгрөгөөр, цэвэр ашгийг 7.5 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 4 дүгээр тогтоолоор бизнес төлөвлөгөөг нийт орлогыг 55.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 63.6 сая төгрөгөөр нэмж тодотгожээ.

Гүйцэтгэлээр 818.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 818.5 сая төгрөгийн зардал гаргаж ажилласан байна. Нийт орлогын гүйцэтгэл 818.5 сая төгрөг байгаа нь төлөвлөснөөс 55.3 сая төгрөг буюу 7.2 хувиар их байна. Үүнд:

- Тариалан сумын Соёл, спортын цогцолбороос 13.1 сая төгрөгийн авлага төлөгдсөн.
- Засгийн газрын тогтоолоор халаалтын хөнгөлөлтөөр 4.3 сая төгрөг орсон
- 2021 оны 10, 11 сарын халаалтын 1.9 сая төгрөгийн орлогыг 2022 оны 01 дүгээр сард нөхөн авсан
- Дулааны талбайн зөрүү илрүүлж, 9.9 сая төгрөгийн нэмэлт орлого орсон.
- Бусад орлогоор 13.7 сая төгрөгийн орлогыг тус тус хүлээж авсан нь нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 818.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:

- Тайланд онд 1 тонн нүүрсний ханш өссөн нь гол нөлөөг үзүүлсэн байна.
- Бизнес төлөвлөгөөнд тээврийн хөлсний зардлыг километр нь 160 төгрөгөөр төлөвлөгдсөн боловч тайлант онд 1 км нь 250 төгрөг болсноос шалтгаалж 39.8 сая төгрөгийн зардал хэтэрсэн байна.

Хүснэгт 2. 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/сая төгрөг/

дд	Үзүүлэлт	2022			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувиар
	Бүтээгдэхүүн үйлдвэрлэл				
1	Халаалтын орлого /НӨАТ-тай дүн/	727.8	755.5	(27.6)	103.0
	Цэвэр усны орлого	18.5	21.9	(3.4)	118.5
	Халуун ус	6.0	8.9	(2.9)	147.8
	Хог, Бохир ус соруулсны орлого	9.4	12.0	(2.6)	124.7
2	НИЙТ ОРЛОГО	763.2	818.5	(55.3)	107.2
3	НИЙТ ЗАРДАЛ	754.9	818.5	(63.6)	108.4
4	Татварын өмнөх ашиг	24.6	(48.9)	(73.5)	(198.0)
5	Цэвэр ашиг /алдагдал/	22.2	(48.9)	(71.1)	(220.3)
8	Нийт ажиллагсдын тоо	32	32	-	100.0
9	Нийт цалингийн сан	246.6	257.5	(10.9)	104.4
15	НИЙТ АВЛАГА	114.6	88.6	(26)	76.7
16	НИЙТ ӨГЛӨГ	15.8	35.4	19.6	224.0
	Үүнээс: Богино хугацаат	15.8	35.4	19.6	224.0

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Тариалан Нийтийн ахуйн үйлчилгээний төв” ХХК -ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зардлын данстай холбоотой, гэрээ хэлцлийн талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хаан Соёмбо Аудит ХХК-ийн чанарын хяналт, ахлах аудитор Н.Бадамханд гүйцэтгэж, хяналтыг анхан шатанд Хаан Соёмбо Аудит ХХК-ийн захирал Х.Диймаа, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

“Тариалан Нийтийн ахуйн үйлчилгээний төв” ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг Хөвсгөл аймаг дахь төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар буюу 14.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 10.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудасны мэдээллийг шалгахад 21.3 сая төгрөгийн мэдээллийг оруулаагүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 371.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 8.1 сая төгрөгийн залруулга хийж, 363.4 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгснийг тайлант онд бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	5	363.4	5	363.4	100
Нийт дүн	5	363.4	5	363.4	100

/сая төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Тариалан сумын Нийтийн аж ахуйн үйлчилгээний газар ХХК-ын ТУЗ нь 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 4 тоот тогтоолоор Хөвсгөл аймгийн ИТХ-аас баталсан зорилтот түвшинд заасан зардлын дүнг 73.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр баталсан "Орон нутгийн өмчит компаниудын 2022 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин батлах тухай" тогтоолын 4 дүгээр хавсралттай нийцэхгүй байна.
- Аймгийн ИТХ-д зорилтот түвшнийг нэмэгдүүлэх хүсэлт тавьсан боловч ТУЗ-аар шийдвэрлүүлэх чиглэл өгсөн. Цаашид зорилтот түвшний зардлын дээд хязгаарыг нэмэгдүүлэхдээ аймгийн ИТХ-ын тогтоолоор батлуулж байгаа эсэхийг дараагийн аудитын анхаарах асуудал гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 0.7 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 0.7 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд: Тариалан сумын "Тариалан Нийтийн ахуйн үйлчилгээний төв" ХХК нь тайлант онд үсчний суудал түрээсэлж 6.8 сая төгрөгийн түрээсийн орлого олсон боловч хөрөнгө түрээслүүлсэн 0.7 сая төгрөгийн татвараа бүртгэж тайлагнаагүй байна. Энэ нь 20.2 Албан татвар төлөгчийн дараах албан татвар ногдуулах орлогод доор дурдсан хувиар тооцож албан татвар ногдуулна " 20.2.1 энэ хуулийн 18.6.1, 18.6.2, 18.6.3, 18.6.7, 18.7-д заасан орлогод 10 хувиар" заалтуудтай нийцэхгүй байна. Иймд татварын өглөгийг 0.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, цэвэр ашгийг 0.7 сая төгрөгөөр бууруулах залруулга хийлээ

Аудитаар нийт 107.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 107.4 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Анхан шатны баримтгүйгээр 86.1 сая төгрөгийн ажил гүйлгээг хийж бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 заалтыг зөрчсөн. "Иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажил гүйлгээг хийхдээ анхан шатны баримтын иж бүрдлийг хангах.

2. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 21.3 сая төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.4, 6.4.5 дахь заалттай тус тус нийцэхгүй байна. "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 зүйлийн дугаар зүйлийн 6.4.4, 6.4.5, хэсэгт заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, иж бүрэн мэдээллэж хэвших.

3. Эдийн засгийн үзүүлэлт, бизнес төлөвлөгөөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Бизнес төлөвлөгөө боловсруулахдаа орлого зардлыг бодитой төлөвлөж хэрэгжүүлээгүйгээс алдагдалтай ажиллах үндэс бий болсон байна.

Өгсөн зөвлөмж: Бизнес төлөвлөгөө боловсруулахдаа орлого зардлыг бодитой төлөвлөж, хэрэгжүүлэх.

4. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: "Тариалан НАҮТ" ХХК нь 2018 онд боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг ашиглаж байгаа бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийгмийн даатгалын багц хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад журам, тушаалуудад гарсан өөрчлөлт, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/сая төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөрөнгө түрээслүүлсэн 0.7 сая төгрөгийн татвараа бүртгэж тайлагнаагүй	1	0.7	1	0.7			1	0.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/сая төгрөгөөр/ Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримтгүйгээр ажил гүйлгээг хийж бүртгэсэн	1	86.1					1	86.1				
Бизнес төлөвлөгөө боловсруулахдаа орлого зардлыг бодитой төлөвлөж хэрэгжүүлээгүй	1	0					1	0				
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг шаардлага хангаагүй	1	0					1	0				
Нийт	3	86.1					3	86.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	/сая төгрөгөөр/ Үүнээс							
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээллээгүй	1	21.3					1	21.3

АУДИТЫН ТАЙЛАНГ:
ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

ЧАНАРЫН ХЯНАЛТ, АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЫМ ОГНОО:

Х.ДИЙМАА

Н.БАДАМХАНД

